



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 146

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох
тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон, нийт 3,399,528,896.00 (гурван тэрбум гурван зуун ерэн есөн сая таван зуун хорин найман мянга найман зуун ерэн зургаан) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Цагдаагийн ерөнхий газрын харьяа Дархан-Уул, Завхан болон Увс аймаг дахь Цагдаагийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Цагдаагийн ерөнхий газрын дарга, хошууч генерал Ж.Болд, Дархан-Уул, Завхан болон Увс аймгийн Орон нутгийн өмчийн газарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Барилгын доорх газар эзэмших эрхийг баталгаажуулах, арга хэмжээний биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132004748

10-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 2 дүгээр сарын 2-ны өдрийн
146 дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ (ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН БАГЦААР)-ЭЭР БИЙ БОЛСОН ЦАГДААГИЙН ӨРӨНХИЙ
ГАЗРЫН ХАРЬЯА ДАРХАН-УУЛ, ЗАВХАН БОЛОН УВС АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ЖАГСААЛТ

| Д/д | Төсөл, арга хэмжээний нэр, байршил | Ашиглалтад орсон он | Арга хэмжээний хүчин чадал | Гүйцэтгэлээрх дүн (төгрөг) | Бүртгэж авах хуулийн этгээдийн нэр |
|-----|---|--|---|----------------------------|-------------------------------------|
| 1 | Цагдаагийн байрны барилгын өргөтгөл, Дархан-Уул аймаг, Дархан сум | 2022 | Тэнхлэгээрээ 11.5м х 24м хэмжээтэй, зоорьтой, 3 давхар, цутгамал төмөр бетон үндсэн хийцтэй, каркасан (1 ком) | 2,437,804,104.90 | Дархан-Уул аймгийн Цагдаагийн газар |
| | Гадна зам талбай, явган хүний зам | | Явган хүний зам талбай, 90 м2 | 120,081,569.00 | |
| | | | Жагсаалын талбайн нөхөн сэргээлт, 220 м2 | | |
| | Гадна дулаан, цэвэр, бохир ус | | Гадна дулааны хос шугам, 251 м | 245,177,248.00 | |
| | | | Гадна цэвэр усны шугам, 172 м | | |
| | | | Бохир ус-8 м | | |
| | | | Дээвэр, 276 м2 | | |
| | Гадна холбооны шугам | Гадна холбоо, 60 м | 68,175,669.10 | | |
| | Цахилгааны кабель утас | Гадна цахилгааны 0.4 кв 3*25+1*16 мм 200м хос кабель | 12,341,021.00 | | |
| | | | | 15,732,276.00 | |
| | | | | 2,899,311,888.00 | |
| 2 | Конторын барилга /кобан/, Завхан аймаг, Отгон сум/ | 2022 | 144 м2 (8м*18м), тоосгон | 157,500,000.00 | Завхан аймгийн Цагдаагийн газар |
| | Гадна дулаан шугам | | Гадна дулааны хос шугам, 110 м | 29,110,905.00 | |
| | | | | | |
| | | | | | |

| | | | | | |
|---|--|------|--------------------------|------------------|---------------------------------|
| 3 | Конторын барилга /кобан/, Увс аймаг, Бөхмөрөн сум/ | 2022 | 144 м2 (8м*18м), тоосгон | 157,474,028.00 | Увс аймгийн Цагдаагийн газар |
| 4 | Конторын барилга /кобан/, Увс аймаг, Өмнөговь сум | | 144 м2 (8м*18м), тоосгон | 156,132,075.00 | |
| | | | Нийт дүн | 313,606,103.00 | |
| | | | Бүгд дүн | 3,399,528,896.00 | |